



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/151

Ховд

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг
түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "л" дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 5 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 15 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирус /covid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хамгаалах зорилгоор аймаг, сумын нутаг дэвсгэрээс гарах, орох хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 10-ны 08.00 цагаас эхлэн 3 дугаар сарын 16-ны өдрийн 08.00 цаг хүртэл хугацаанд түр зогсоосугай.

2.Аймгийн болон сумдын хилийн заагууд дээр хяналтын пост ажиллуулж, үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Б.Алтанбадралт/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/151 Ch

02 00668